# МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 07 өдөр Дугаар А/132 Улаанбаатар хот

"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралт ёсоор батлагсугай.

2. Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолын 6.3.6-д заасан болон арга хэмжээний хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд Жендэрийн үндэсний хорооны ажлын албанд ирүүлсүгэй.

3. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний салбар дундын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хүн амын хөгжлийн газар (С.Тунгалагтамир)-т үүрэг болгосугай.

4. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр", түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох журмын дагуу Засгийн газарт танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Мөнхзул)-т үүрэг болгосугай.

САЙД Н.НОМТОЙБАЯР

08 412

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын*
*2017 оны 08 дугаар сарын 07-ний өдрийн*
*А/132 тушаалын хавсралт*

# ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2017-2021)

| | |
|---|---|
| **Зорилго** | Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн цогц арга хэмжээгээр хуулийн хэрэгжилтийг дэмжих, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах |
| **Үр дүн** | 1. **Салбаруудын жендэрийн бодлого болон бүх аймаг, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөр батлагдсан байна.**<br>2. **Жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдсөн байна.**<br>3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавх бэхжсэн байна.<br>4. **Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж бүх аймаг, дүүрэгт ажиллана.**<br>5. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсэн байна. |

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.** Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх | | | | | | |
| 1.1 | Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, | байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын | хөдөлмөрийн дотоод журамдаа | ХНХЯ[1] | ХЭҮК[2], ХЗДХЯ[3], МҮХАҮТ[4], | 2018-2021 |

[1] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
[2] Хүний эрхийн үндэсний комисс
[3] Хууль зүйн, дотоод хэргийн яам
[4] Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн тэнхим

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд тусгуулан хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлж нэвтрүүлэх | хэрэгжилтийг хэмжих үзүүлэлт бүхий удирдамж | удирдамжийг ашигласан байгууллагын тоо, хувь | | АОЭНХ[5], МҮЭХ[6], ОУБ[7] | |
| 1.2 | Иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохицуулалтыг хуульд тусгах | Хууль тогтоомжийн төсөл | Хууль тогтоомжийн зохицуулалтын байдал, хувь | ХЗДХЯ | ХЭҮК, ХНХЯ, МҮЭХ, МҮХАҮТ, АОЭНХ | 2018-2021 |
| 1.3 | Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогыг үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ авах | ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогын баримт бичиг | бодлогыг нэвтрүүлсэн байгууллагын тоо, хувь | ХНХЯ | МҮЭХ, ТББ[8], ОУБ | 2018-2020 |
| 1.4 | Адил хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэй, эрэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох үнэлгээний аргачлал боловсруулах | үнэлгээний аргачлал | үнэлгээний аргачлалын хэлэлцүүлгийн тоо | ХНХЯ | МҮЭХ, МҮХАҮТ, АОЭНХ ОУБ | 2018-2019 |
| 1.5 | Малчин, тариаланч өрхийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, арга хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, шийдвэр гаргагчид зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавих | жендэрийн дүн шинжилгээний тайлан, зөвлөмж | зөвлөмжийг хэрэгжүүлсэн байгууллагын тоо | ХХААХҮЯ[9] | ХНХЯ, ТББ, ОУБ | 2018-2020 |
| 1.6 | Эмэгтэй, эрэгтэй хүн болон нийгмийн бүлгийн хэрэгцээнд нийцсэн, тэгш хүртээмжтэй ногоон ажлын байр бий | судалгааны тайлан | сайн туршлагыг түгээсэн нөлөөллийн үйл | БОАЖЯ[10] | ХНХЯ, ТББ, ОУБ | 2018-2019 |

[5] Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
[6] Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо
[7] Олон улсын байгууллага
[8] Төрийн бус байгууллага
[9] Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
[10] Байгаль орчин, аялал жуулчлалын яам

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | болгох үндэсний болон бусад улсын сайн туршлагыг судлах | | ажиллагааны тоо | | | |
| 1.7 | Ядуурлын эсрэг, тэгш оролцоот, хүртээмжит ногоон хөгжлийн хандлагыг нэвтрүүлэх гарын авлага боловсруулан түгээх | гарын авлага | гарын авлага түгээсэн байгууллагын тоо | БОАЖЯ | ХНХЯ, ТББ, ОУБ | 2018-2019 |
| 1.8 | Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой, өрх толгойлсон эцэг (эх)-ийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих | үйл ажиллагааны төлөвлөгөө | үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | ХНХЯ | ХХҮЕГ[11], ТББ, ОУБ | 2018-2021 |
| 1.9 | Гэр бүл төлөвлөлтийн талаар боловсрол олгох нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх эмч, мэргэжилтний ур чадварыг сайжруулах, иргэдийн насны онцлогт тохирсон мэдээлэл, сурталчилгаа хийх | эмч, мэргэжилтэнд зориулсан сургалт, мэдээлэл сурталчилгаан ы материал | сургалтанд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо мэдээлэл, сурталчилгааны тоо | ЭМЯ[12] | ХНХЯ, ГБХЗХГ[13], ТББ, ОУБ | 2018-2021 |
| 1.10 | Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетийг бүх аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвд ажиллуулж, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжөөр хангах | хүний нөөц, техник төхөөрөмж, тасаг, кабинет | эрэгтэйчүүдийн тасаг, кабинеттай аймаг, дүүргийн тоо, эмч нарын тоо | ЭМЯ | СЯ[14], аймаг, дүүргийн ЗДТГ[15], Нэгдсэн эмнэлэг, НӨУБ[16] | 2018-2021 |

11 Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
12 Эрүүл мэндийн яам
13 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
14 Сангийн яам
15 Засаг даргын тамгын газар
16 Нутгийн өөрөө удирдах байгууллага

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.11 | Улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхлэгч, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх | жендэрийн дүн шинжилгээний тайлан | дүн шинжилгээний зөвлөмжийг танилцуулж, сурталчилсан арга хэмжээний тоо | ЭМЯ | УУХҮЯ[17], ХНХЯ, Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, НӨУБ, ТББ, ОУБ | 2019-2020 |
| 1.12 | Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх чадавх олгох цуврал сургалт зохион байгуулах | цуврал сургалтын хөтөлбөр | цуврал сургалтанд хамрагдагчийн тоо, хувь | ЭМЯ | ТББ, ОУБ | 2017-2018 |
| 1.13 | Эрүүл мэнд, нөхөн үржихүй, бэлгийн боловсрол олгох хичээлийн агуулгыг насны болон жендэрийн хувьд өвөрмөц хэрэгцээт бүлгийн онцлогт тохируулан боловсруулж, ерөнхий боловсролын сургуульд албан сургалтаар, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт сонгон судлах хичээлийн хөтөлбөрт оруулах | хичээлийн хөтөлбөр | ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тусгасан хувь | ЭМЯ | БСШУСЯ[18] | 2018-2020 |
| **Зорилт 2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх** | | | | | | |
| 2.1 | Жендэрийн статистикийг нэгтгэн боловсруулах программ хангамжийг нэвтрүүлэх | программ хангамж | программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байгууллагын тоо | ҮСХ[19] | ХНХЯ, ОУБ | 2017-2018 |
| 2.2 | Жендэрийн статистикийг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулж хуулиар үүрэг | аргачлал | аргачлалыг ашигласан байгууллагын | ХНХЯ/ЖҮХ[20] | холбогдох төрийн байгууллагууд, | 2018 |

[17] Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
[18] Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
[19] Үндэсний статистикийн хороо
[20] Жендэрийн үндэсний хороо

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүлээгчдэд хүргүүлэх | | хувь | | ТББ | |
| 2.3 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг үндэсний хэмжээнд хэлэлцүүлэх, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгах арга хэмжээ авах | хяналт шинжилгээ үнэлгээний тайлан | хэлэлцүүлгийн тоо | ХНХЯ/ЖҮХ | ТББ, ОУБ | 2018 |
| 2.4 | Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа эмэгтэй, эрэгтэй тэтгэвэр авагчдын дунд судалгаа хийж, тэтгэврийн зөрүүтэй байдлыг арилгах талаар санал боловсруулах | судалгааны тайлан | саналын хэлэлцүүлгийн тоо | ХНХЯ | ЭМНДЕГ[21], ТББ, ОУБ | 2018-2019 |
| 2.5 | Иргэдийн газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд тусгах чиглэлээр ажиллах | дүн шинжилгээний тайлан | үр дүнг тусгасан бодлого, үйл ажиллагааны тоо | ХНХЯ/ЖҮХ | ХЗДХЯ, ОӨУБЕГ[22], ТББ, ОУБ | 2018-2020 |
| 2.6 | Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвх болон оролцоо, тэднийг үнэлэх үнэлэмж, хандлага, гэр бүлийн хүрээнд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийх | судалгааны тайлан | судалгааны хэлэлцүүлгийн тоо | ХНХЯ/ЖҮХ | ЭМЯ, БСШУСЯ, ГБХЗХГ, ТББ, ОУБ | 2018-2019 |
| 2.7 | Залуу малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгуулах арга хэмжээ авах | судалгааны тайлан | авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | ХХААХҮЯ | ХНХЯ, ГБХЗХГ, аймаг, дүүргийн ЗДТГ, ТББ, ОУБ | 2018-2019 |
| 2.8 | Салбарын болон орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх | оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээг хэлэлцсэн | оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийсэн салбар, орон | ХНХЯ/ЖҮХ | Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, | 2017-2021 |

[21] Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар
[22] Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тайлан | нутгийн тоо | | нийслэл, дүүргийн ЗДТГ, ТББ, ОУБ | |
| 2.9 | Орон нутгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хороодоос сум, баг, хороотой хамтран ажиллах удирдамж гаргах | удирдамж | удирдамжийг хэрэгжүүлсэн нэгжийн тоо | ХНХЯ/ЖҮХ | Аймаг, нийслэл, сум дүүрэг, баг, хорооны ЗДТГ, НӨУБ, ТББ, ОУБ | 2018-2019 |
| 2.10 | Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгах | бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгох зохицуулалт | үр дүнгийн гэрээнд тусгасан тоо, хувь | ХНХЯ/ЖҮХ | Аймаг, нийслэл, сум дүүргийн, ЗДТГ, НӨУБ, ТББ | 2018-2021 |
| 2.11 | Салбарын жендэрийн нэгдсэн бодлого, аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх | үйл ажиллагааны төлөвлөгөө | батлагдсан салбарын жендэрийн бодлого, дэд хөтөлбөрийн тоо | ХНХЯ/ЖҮХ | ТББ, ОУБ | 2017-2021 |
| 2.12 | Төрийн байгууллагын төсөв боловсруулах үүрэгтэй ажилтныг жендэрийн мэдрэмжтэй төсөв хийх цахим сургалтад хамруулах | цахим сургалтын хөтөлбөр | сургалтанд хамрагдагчдын тоо | СЯ | Төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, НӨУБ, ТББ | 2018-2021 |
| 2.13 | Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендэрийн дүн шинжилгээ хийж, төсвийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, үнэлэх аргачлал боловсруулах | гарын авлага, аргачлал | төсвийн жендэрийн мэдрэмжийг үнэлэх аргачлал, гарын авлага хэрэглэсэн байгууллагын тоо, хувь | СЯ | ТББ, ОУБ | 2017-2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.14 | Гадаад улсын болон олон улсын байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр манай улсад оруулсан хувь нэмэр, зарцуулсан санхүүжилтийн талаарх мэдээллийг нэгтгэн, зөвлөмж хүргүүлэх | зөвлөмж | зөвлөмж хүргүүлсэн байгууллагын тоо, хувь | ХНХЯ/ЖҮХ | СЯ, ТББ | 2018-2021 |
| **Зорилт 3. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх** | | | | | | |
| 3.1 | Багш бэлтгэх сургууль болон багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт жендэрийн үнэлгээ хийж, жендэрийн асуудлыг тусгах | жендэрийн үнэлгээний тайлан | жендэрийн асуудлыг тусгасан сургуулийн тоо | БСШУСЯ | ТББ, ОУБ | 2017-2018 |
| 3.2 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар боловсрол (цэцэрлэгийн болон бага ангийн багш), эрүүл мэнд (эмч, сувилагч, асрагч)-ийн чиглэлээр суралцах эрэгтэйчүүд, мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцах эмэгтэйчүүдийг нэмэгдүүлэх | бодлогыг хэрэгжүүлэх шийдвэр | боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь<br><br>Мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь | БСШУСЯ | ТББ | 2018-2020 |
| 3.3 | Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, сурах бичигт жендэрийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих ойлголт, хандлагыг | сургалтын хөтөлбөр | сургалтын хөтөлбөрт тусгасан байдал, хувь | БСШУСЯ | ХЗДХЯ/ГХУСА ЗЗ, ХНХЯ, ТББ | 2017-2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төлөвшүүлэх асуудлыг тусгах | | | | | |
| 3.4 | Бусдыг хүндлэх, гэр бүлийн болон ойр дотны хүнээ хайрлан хүндлэх, хүнлэг чанарыг эрхэмлэх, эрүүл амьдралын зан үйлд суралцаж хорт, буруу зуршлаас ангижрах арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулах | сургалт, сурталчилгааны төлөвлөгөө, хөтөлбөр | сургалтанд хамрагчдын тоо,<br><br>сурталчилгааны тоо | ХНХЯ | ГБХЗХГ, ТББ, ОУБ | 2017-2018 |
| 3.5 | Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах | арга хэмжээний төлөвлөгөө | зохион байгуулсан арга хэмжээний тоо | ХНХЯ | ГБХЗХГ, ТББ, ОУБ | 2017-2018 |
| 3.6 | Гэр бүл судлалыг хөгжүүлэх, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх арга хэмжээг дэмжиж, хүний нөөцийг бэлтгэх; | эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөө өгөх бүтэц, хүний нөөц | эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөө өгөх бүтэцтэй аймаг, дүүргийн тоо | ХНХЯ | ГБХЗХГ, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, ТББ | 2017-2021 |
| 3.7 | Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас Олон улсын сэтгүүлчдийн холбоо болон бусад түнш байгууллагатай хамтран боловсруулсан “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-ийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах; | шалгуур үзүүлэлт, баталсан бодлого, ёс зүйн код | шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн ахисан хувь | ХНХЯ/ЖҮХ | СНЭ[23], Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ[24], ОУБ | 2018-2019 |
| 3.8 | Хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй байдалд дүн шинжилгээ хийх | жендэрийн дүн шинжилгээний тайлан | дүн шинжилгээний зөвлөмж хүргүүлсэн | ХНХЯ/ЖҮХ | СНЭ, Хэвлэлийн хүрээлэн болон бусад | 2018 |

[23] Сэтгүүлчдийн нэгдсэн эвсэл
[24] Хэвлэл мэдээллийн байгууллага

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагын тоо, хувь | | ХМБ, ТББ, ОУБ | |
| 3.9 | Сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгаж, сэтгүүлчдийг жендэрийн чиглэлээр үе шаттай сургалтад хамруулах | хөтөлбөрийн жендэрийн агуулга, сургалт | жендэрийн агуулга бүхий хөтөлбөртэй сургууль, сургалтад хамрагдагчийн тоо, хувь | ХНХЯ/ЖҮХ | БСШУСЯ, СНЭ, Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ, ТББ | 2017-2021 |
| 3.10 | Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн шинэлэг дүр төрхийг бий болгох ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттайгаар зохион байгуулах | компанит ажлын хөтөлбөр, төлөвлөгөө | компанит ажилд оролцсон ХМХ, үйл ажиллагааны тоо | ХНХЯ/ЖҮХ | СНЭ, Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ, ОУБ | 2018-2021 |
| 3.11 | Соёл урлагийн салбарын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтыг арилгах жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх | бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө | үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байгууллагын тоо | БСШУСЯ | ТББ, ОУБ | 2018-2021 |
| 3.12 | Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг хариуцлагыг өндөржүүлж, жендэрийн асуудлаар тусгайлсан нийтлэл, нэвтрүүлгийг тогтмол гаргах | нийтлэлийн булан Нэвтрүүлэг | нийтлэлийн булан, нэвтрүүлгийн цагтай хэвлэл мэдээллийн байгууллагын тоо | ХНХЯ/ЖҮХ | СНЭ, Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ, ОУБ | 2018-2021 |
| 3.13 | Эрэгтэйчүүд, ялангуяа 18-35 насныханд зориулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, үндэсний уламжлалт, дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх | сургалт, төсөл хөтөлбөр | оролцогчдын хувь | ХНХЯ/ЖҮХ | ГБХЗХГ, ТББ, ОУБ | 2017-2021 |
| 3.14 | Нийгэм дэх манлайлагч, олны танил | сурталчилгаан | сурталчилгаа | ХНХЯ/ЖҮХ | СНЭ, | 2018-2021 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | эрүүл амьдралын зан үйл, дадал эзэмшсэн эрэгтэйчүүдийн ололт, амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх | ы материал | хийсэн ХМХ-ийн тоо, хувь | | Хэвлэлийн хүрээлэн болон бусад ХМБ, ТББ, ОУБ | |
| **Зорилт 4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх** | | | | | | |
| 4.1 | Жендэрийн салбар зөвлөл болон хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загварыг баталж мөрдүүлэх | журам | журмыг мөрдсөн салбар зөвлөл, хорооны тоо | ХНХЯ/ЖҮХ | | 2017-2021 |
| 4.2 | Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх Жендэрийн шинжээчдийн бүлэг, Жендэр консорциум, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих | төлөвлөгөө | төлөвлөгөөний биелэлтийн хувь | ХНХЯ/ЖҮХ | ТББ, ОУБ | 2017-2021 |
| 4.3 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх | үнэлгээний тайлан | тайлангийн хэлэлцүүлэгт оролцогчдын тоо | ХНХЯ/ЖҮХ | ТББ, ОУБ | 2017-2021 |
| 4.4 | Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үндэсний сургагч багш бэлтгэх | сургалтын төлөвлөгөө | бэлтгэгдсэн сургагч багшийн тоо | ХНХЯ/ЖҮХ | ТАЗ[25], ТББ, ОУБ | 2017-2021 |
| 4.5 | Сум, хорооны Засаг даргын Тамгын газрын залуучууд, гэр бүл, хүн амын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага боловсруулж, сургалтад хамруулах | гарын авлага | сургалтанд оролцогчдын тоо | ХНХЯ | ГБЗХГ, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, ТББ, ОУБ | 2018-2021 |
| 4.6 | Удирдах ажилтанд зориулсан жендэрийн цахим сургалтын модуль боловсруулан нэвтрүүлэх | цахим сургалтын модуль | сургалтанд оролцогчдын тоо | ХНХЯ/ЖҮХ | ТАЗ, ЗГХЭГ[26], СЯ, УА[27], ТББ, ОУБ | 2017-2021 |
| 4.7 | Монголын үндэсний худалдаа, аж | аж ахуйн нэгж | жендэрийн | ХНХЯ | МҮХАҮТ, ТББ, | 2018-2019 |

[25] Төрийн албаны зөвлөл
[26] Засгийн газрын хэрэг эрхлэх газар
[27] Удирдлагын академи

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрийн танхимтай хамтран шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах шалгуурт жендэрийн эрх тэгш байдлын үзүүлэлтийг тусгах | шалгаруулах шалгуур дахь жендэрийн үзүүлэлт | үзүүлэлтийн тоо | | ОУБ | |
| 4.8 | Ажил олгогч, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих хөшүүргийг тодорхойлж сурталчлах | жендэрийн тэгш байдлыг дэмжих санхүү эдийн засаг, бизнес, техник технологийн хөшүүргүүдийг тодорхойлсон зөвлөмж | зөвлөмжийг сурталчилсан арга хэмжээний тоо | ХНХЯ | МҮХАҮТ, МҮЭХ, АОЭНХ, ТББ, ОУБ | 2018-2020 |
| 4.9 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэн урамшуулах | сайн туршлага бүхий сурталчилгаан ы материал | сурталчилгааны тоо | ХНХЯ/ЖҮХ | МҮХАҮТ, МҮЭХ, АОЭНХ, ТББ, ОУБ | 2018-2020 |
| 4.10 | Аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр орон нутаг дахь төрийн бус байгууллагын чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | ТББ-уудын хийсэн үнэлгээний тайлан | үнэлгээ хийлгэсэн аймаг, нийслэл, дүүргийн тоо | ХНХЯ/ЖҮХ | ТББ, ОУБ | 2017-2021 |
| **Зорилт 5. Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх** | | | | | | |
| 5.1 | Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах заавар боловсруулан Хүний эрхийн үндэсний комисс болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл, холбогдох ажилтанд хүргүүлж, сургалтад | сургалтын хөтөлбөр | оролцогчдын тоо, хувь | ХЭҮК | ХНХЯ, ГБХЗХГ, ГХУСАЗЗ[28], ТББ, ОУБ | 2017-2019 |

[28] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хамруулах | | | | | |
| 5.2 | Охид, эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх | үйл ажиллагааны төлөвлөгөө | төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | ХЗДХЯ | ХНХЯ, ЦЕГ[29], ГХУСАЗЗ, ТББ, ОУБ | 2017-2021 |
| 5.3 | Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх | мэдээлэл сурталчилгаа | мэдээлэл түгээсэн байдал, хувь | ХЗДХЯ/ ГХУСАЗЗ | ХНХЯ, СНЭ, Хэвлэлийн хүрээлэн, бусад ХМБ, ТББ, ОУБ | 2017-2021 |
| 5.4 | Аж ахуйн нэгж, байгууллагад хүчирхийлэл, түүний дотор ажлын байр дахь бэлгийн дарамт гарахаас сэргийлэх, хохирогчийн хүсэлт, гомдлыг ажил олгогчийн зүгээс шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх | хууль тогтоомжийн төсөл | хууль тогтоомжийн зохицуулалтын байдал, хувь | ХНХЯ | МҮЭХ, МҮХАТ, АОЭНХ, ТББ, ОУБ | 2017-2018 |
| 5.5 | Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж (Нэг цэгийн үйлчилгээний төв, Хамгаалах байр зэрэг)-ийг бүх аймагт ажиллуулж, үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх | хохирогчийг хамгаалах нэгж | төсөвт үйл ажиллагааны зардал нь тусгагдсан хохирогчийг хамгаалах нэгжийн тоо | ХЗДХЯ/ ГХУСАЗЗ | ХНХЯ, СЯ, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, НӨУБ, ТББ, ОУБ | 2017-2021 |
| **Зорилт 6. Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх** | | | | | | |
| 6.1 | Улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүнийг санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг тогтоож, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэх | квотын хэрэгжилт | квотыг хэрэгжүүлсэн улс төрийн болон төрийн захиргааны байгууллагын тоо | ТАЗ | Төрийн захиргааны төв болон захиргааны байгууллага, улс төрийн нам | 2017-2021 |
| 6.2 | Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, | хамтын ажиллагааны | хөтөлбөрт хамтрагдсан | ХНХЯ/ЖҮХ | ТББ, ОУБ | 2017-2021 |

[29] Цагдаагийн ерөнхий газар

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | манлайллыг бий болгох чиглэлээр эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах | хөтөлбөр | ТББ-ын тоо | | | |
| 6.3 | Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх арга хэмжээ авах | арга хэмжээний төлөвлөгөө | жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлсэн байгууллагын тоо | ХНХЯ/ЖҮХ | НӨУБ, ТББ, ОУБ | 2018-2021 |